

**ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, АРХИТЕКТУРЫН
ОРОН ТООНЫ БУС МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН
ЧИГ ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ**

2020 оны 02 дүгээр
сарын 04-ны өдөр

Дугаар.....2020/34

Улаанбаатар хот

Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1, 34 дүгээр зүйлийн 34.1.13 дахь заалт, 34.2 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн 22 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор нэг талаас Барилга, хот байгуулалтын яам /цаашид "яам" гэх/, нөгөө талаас "Монголын Архитекторуудын Эвлэл" төрийн бус байгууллага/цаашид "МАЭ" гэх/ харилцан тохиролцож "Хот төлөвлөлт, архитектурын орон тооны бус мэргэжлийн зөвлөл" /цаашид "зөвлөл" гэх/-ийн үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг "Монголын архитекторуудын эвлэл" төрийн бус байгууллагаар үргэлжүүлэн гүйцэтгүүлэхээр энэхүү гэрээг 2020 оны 02 дугаар сарын 04-ны өдөр байгуулав.

Нэг. Барилга, хот байгуулалтын яамны эрх, үүрэг

1.1. Яамны зохион байгуулалтын бүтцийн нэгж /газар/ зөвлөлийн хэлэлцэх асуудлын талаар санал өгч, хэлэлцсэн асуудлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тухай бүр авч байна. Тодорхой асуудлыг зөвлөлөөр хэлэлцүүлэх санал гаргаж болно.

1.2. МАЭ-ийг архитектур, хот төлөвлөлтийн салбарын бодлогын асуудлаар яамтай харилцах мэргэжлийн төрийн бус /олон нийтийн/ байгууллагын нэг гэж үзнэ.

1.3. Архитектур, хот төлөвлөлтийн салбарын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, төсөл хөтөлбөр, стратеги төлөвлөгөө боловсруулах, хэлэлцэх, шийдвэрлэх, хэрэгжүүлэхэд МАЭ-ийн оролцоог хангаж, хамтран ажиллана.

1.4. Архитектур, хот төлөвлөлтийн салбарын мэргэжлийн үйл ажиллагааны чиглэлээр яаманд байгуулагдах комисс, зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд МАЭ-ийн төлөөллийг оролцуулж болно.

1.5. Архитектур, хот төлөвлөлтийн чиглэлийн норм, дүрэм, стандарт боловсруулах ажилд МАЭ-ийн саналыг авч, хамтран ажиллана.

1.6. Салбарын хэмжээнд, захиалагч, хөрөнгө оруулагч, зураг төслийн байгууллагыг зөвлөлийн үйл ажиллагааны талаарх мэдээллээр хангана.

1.7. Зөвлөлийн бүрэлдэхүүнд /шаардлагатай тохиолдолд/ салбарын мэргэжлийн зөвлөлд, бусад зураач, барималч, түүхч, археолог зэрэг шилдэг мэргэжилтэн, судлаач, эрдэмтнийг оролцуулна.

1.8. Зөвлөл үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгож болно.

1.9. Яам нь зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах, сайжруулах чиглэлээр МАЭ-ийн хүний нөөц, санхүүгийн чадавхид эрх бүхий байгууллага, эсхүл яамны зохион байгуулалтын нэгжээр үнэлгээ хийлгэж, санал, дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулах эрхтэй.

1.10. Зөвлөл тусгайлсан дүрэмтэй байх шаардлагатай гэж үзвэл дүрмийн төслийг боловсруулан батлуулах ажлыг зохион байгуулна.

1.11. Энэ гэрээний 3.3-т заасны дагуу гэрээг цуцлах тохиолдолд энэ тухай санал бэлтгэж, зохих журмын дагуу шийдвэрлүүлнэ.

**Хоёр. “Монголын архитекторуудын зөвлөл” төрийн бус байгууллагын
эрх, үүрэг**

2.1. МАЭ нь “Төрийн бус байгууллагын дүрэм”-дээ зөвлөлийг зохион байгуулах талаар тусгасан байна.

2.2. Барилгын тухай хууль, төгтоомж, бусад хууль тогтоомж, эрх зүйн акт, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 160 дугаар тушаалаар баталсан “Архитектор, инженерийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам”-ын дагуу зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулж, хэвийн үйл ажиллагааг нь хангаж ажиллана.

2.3. МАЭ нь архитектур, хот төлөвлөлтийн чиглэлээр олон улсын хэм хэмжээ, олон улсын туршлага, шинэ технологийг Монголын салбарт нутагшуулах, хэрэглэх талаар мэргэжлийн төрийн бус байгууллагын гүйцэтгэх чиг үүрэгт хамааралтай эрх зүйн актын зохицуулалтыг оновчтой болгох талаар санал гаргаж болно.

2.4. Зөвлөлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй, шударга, хууль дүрэм, журмын хүрээнд эрхлэн гүйцэтгэж, гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлнэ.

2.5. Яамны холбогдох зохион байгуулалтын бүтцийн нэгжийн саналыг үндэслэн тухайн асуудыг зөвлөлөөр хэлэлцэж, дэлгэрэнгүй мэдээлэл /хэлэлцсэн асуудлын танилцуулга, холбогдох материал, хуралдааны тэмдэглэл, шийдвэр, зөвлөмж/-ийг тухай бүр яаманд хүргүүлж, шаардлагатай бусад мэдээллээр хангах үүрэгтэй.

2.6. Зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар санал гаргаж шийдвэрлүүлнэ.

2.7. Зөвлөлийн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ захиалагч, хөрөнгө оруулагч, зураг төслийн байгууллага, салбарын төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулж холбогдох мэдээллээр тухай бүр хангаж ажиллана.

2.8. Зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнийг Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар баталгаажуулна.

2.9. Зөвлөлийн үйл ажиллагааг яаманд хагас, бүтэн жил тутам тайлагнаж, холбогдох заавар, чиглэл авч ажиллана.

2.10. Барилгын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, 10.1.5 дахь заалт, бусад эрх зүйн актад тусгайлан заасан барилга, байгууламжийн зураг төслийг тус зөвлөлөөр хэлэлцүүлэгүй захиалагч, зураг төслийн байгууллагын үйл ажиллагааны талаар холбогдох санал гаргах үүрэгтэй.

2.11. Зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдох баримт бичгийг архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомж, дүрмийн дагуу хөтлөж, хадгалах үүрэгтэй.

Гурав. Хариуцлага

3.1. МАЭ гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явцад бусад этгээдэд хохирол учруулсан бол өөрийн хөрөнгөөр бүрэн хариуцаж барагдуулна.

3.2. Зөвлөл зөвлөмж гаргах болон бусад байгууллага, иргэнтэй харилцахдаа МАЭ-ийн хэвлэмэл хуудас, тэмдгийг хэрэглэнэ.

3.3. Дараах нөхцөлийн аль нэг нь бий болсон тохиолдолд яамны санаачилгаар гэрээг цуцалж, үүний улмаас хохирол учирсан бол хохирлыг МАЭ үл маргах журмаар хариуцан барагдуулна. Үүнд:

3.3.1. зөвлөлийн гишүүдээс үл хамаарах шалтгаанаар зөвлөлийн хуралдааныг хийгээгүй зөрчил гаргасан /гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, байгалийн гамшиг, нийтийг хамарсан эмх замbaraагүй байдал, үймээний улмаас хуралдаан хийгээгүйг зөрчил гэж үзэхгүй/;

3.3.2. зөвлөл, зөвлөлийн гишүүнийг хараат бус байдал, зөвлөлийн үйл ажиллагаа, гарах зөвлөмжид МАЭ, түүний ажилтан нөлөөлсөн, нөлөөлөхийг завдсан, ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөл үүсгэсэн;

3.3.3. зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах хүний нөөц, эд хөрөнгийн чадавхигүйг эрх бүхий байгууллага тогтоосон;

3.3.4. хуульд тусгайлан заасан бусад.

3.4. Гэрээтэй холбоотой асуудлаар маргаан үүссэн бол хууль тогтоомжийн хүрээнд харилцан тохиролцон шийдвэрлэнэ. Ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол Монгол Улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

Дөрөв. Бусад зүйл

4.1. Гэрээ 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдөр хүртэл 3 /гурав/ жилийн хугацаанд хүчинтэй байна.

4.2. Энэ гэрээний 4.1-т заасан хугацааг сунгах, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд саналаа нөгөө талд 14-өөс доошгүй хоногийн өмнө албан бичгээр мэдэгдэнэ.

4.3. Энэхүү гэрээний нэгдүгээр хавсралтаар баталсан чиг үүргийг гүйцэтгүүлэх ажлын төсөв нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.4. Энэ гэрээг 3 хувь үйлдсэн бөгөөд яам 2, МАЭ 1 хувийг тус тус хадгална.

4.5. Гэрээний биелэлтийг хагас, бүтэн жил тутам дүгнэж ажиллана.

4.6. Гэрээний хугацаа дууссанаар гэрээг цуцлах санал гаралтай нөхцөлд талууд энэ гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гэрээний хугацаа сунгах, шинээр гэрээ байгуулах хүртэл хэвээр үргэлжилнэ.

Гэрээ байгуулсан:


БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

С.МАГНАЙСҮРЭН

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМНЫ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА


Д.БАЯРСАЙХАН

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМНЫ ХОТ БАЙГУУЛАЛТ, ГАЗРЫН
ХАРИЛЦААНЫ БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ
ГАЗРЫН ДАРГА


Б.ГҮНБОЛД

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,
Засгийн газрын XII байр,
Барилгачдын талбай-3, Улаанбаатар-
15170
Е-майл: info@maud.gov.mn
<http://www.maud.gov.mn>

“МОНГОЛЫН АРХИТЕКТОРУУДЫН
ЭВЛЭЛ” ИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ

Э.ХҮРЭЛБААТАР

“МОНГОЛЫН АРХИТЕКТОРУУДЫН
ЭВЛЭЛ” ТӨРИЙН БУС
БАЙГУУЛЛАГЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ


Т.ГАНЗОРИГ

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 8 дугаар
хороо, Болгарын гудамж- 27 тоот
Улаанбаатар- 14191
Е-майл: uma.org.mn@gmail.com
www.uma.org.mn